РРТ 1. ЭЗ ӨСӨЛТ

- Монгол Улсын эдийн засаг 2026 оны эхний 8 сарын байдлаар 7.3 хувиар өсөж, сүүлийн таван жилийн хамгийн өндөр өсөлтөд хүрээд байна. Энэхүү өсөлтийг голлон уул уурхай болон тээврийн салбарууд бүрдүүлж, нийт эдийн засгийн өсөлтийн 4.1 нэгж хувийг дангаараа хангажээ. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад эрэлт, тэр дундаа БНХАУ-ын импортын эрэлт өндөр хэвээр хадгалагдаж байгаа нь экспорт, үйлдвэрлэл, тээврийн үйл ажиллагааг дэмжих гол хүчин зүйл болж байна. Харин дотоод эрэлтийн талд худалдаа, үйлчилгээ зэрэг уул уурхайн бус салбаруудын өсөлт саарч байгаа нь өндөр инфляцын нөлөөгөөр өрхийн бодит орлого болон худалдан авах чадвар суларч, хэрэглээний өсөлт саарч байгааг илтгэж байна.
- Улсын дундаж нэрлэсэн цалин 2.9 сая төгрөгтэй тэнцэж 8.1 хувиар өссөн ч өрхийн бодит орлого болон зарлага 4.8 хувиар буурсан. Өрхийн бодит орлого буурсан гол шалтгаан нь цалингийн өсөлт бага байсантай холбоотой бус ХАА бус үйлдвэрлэлийн орлого болох худалдаа, үйлчилгээний орлого буурсан нь гол нөлөөг үзүүлсэн.
- За ийнхүү хэрэглээний аргаар тооцсон эдийн засгийн үзүүлэлт 2026 оны эхний хагаст 7.8 хувь гарчээ. Голлох оролцоог авч үзвэл өрхийн хэрэглээ нийт эдийн засгийн өсөлтийн ердөө 0.4 хувийг бүрдүүлж байна. Харин засгийн газрын хэрэглээ 0.9 хувийг бүрдүүлж байгаа нь эдийн засгийн өсөлтийг хэрэглээ бус зөвхөн цэвэр экспортын дүн дангаараа тайлбарлаж байна. Цэвэр экспорт 2-р улирлын байдлаар нийт өсөлтийн 12.9 хувийг бүрдүүлсэн. Харин хөрөнгийн хуримтлал өсөлтийг 6.5 нэгж хувиар доош татсан байна.
- Уул уурхайн бус салбар болох худалдаа, үйлчилгээний салбар өмнө жилтэй харьцуулахад 0.2 хувиар буурсан нь өрхийн орлого буурч эдийн засгийн идэвхжил саарч байгааг илтгэж байна.

РРТ 2. ГАДААД ХУДАЛДАА

- Эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч хэвээр байгаа уул уурхайн салбар нь нүүрс, зэс зэрэг экспортын гол бүтээгдэхүүний гадаад эрэлт өндөр, хил дамнасан ложистик болон тээврийн нөхцөл тогтвортой байгаатай холбоотойгоор үргэлжлэн тэлж байна. Тухайлбал, III улирлын байдлаар БНХАУ руу экспортолсон нүүрсний биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 41 хувиар өсөж 82.3 сая тоннд хүрсэн бол дэлхийн зах зээл дэх металлын үнийн өсөлтийн нөлөөгөөр зэсийн экспортын дундаж үнэ 34 хувиар өсөж, нэг тонн нь 3,598 ам.долларт хүрсэн байна. Энэ нь Монгол Улсын экспортын орлого болон гадаад валютын урсгалыг дэмжих гол хүчин зүйл болж байна.
- Эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр нийт экспорт 16.2 тэрбум ам.доллар, импорт 9.7 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 6.5 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна. Экспортын орлого өсөн нэмэгдэж байгаа хэдий ч уул уурхайн үйлдвэрлэл, дэд бүтцийн бүтээн байгуулалт эрчимтэй үргэлжилж байгаатай холбоотойгоор шатахуун, уул уурхайн техник тоног төхөөрөмж, машин механизм болон үйлдвэрлэлийн зориулалттай барааны импорт өндөр хэвээр байна. Өөрөөр хэлбэл, экспортын өсөлт нь гадаад эрэлтийн хүчтэй нөхцөлөөс шалтгаалж байгаа бол импортын өсөлт нь хөрөнгө оруулалт болон үйлдвэрлэлийн идэвхжилтэй холбоотой дотоод эрэлтийг илэрхийлж байна.

- Экспортын орлого нэмэгдэж, гадаад худалдааны ашиг өндөр түвшинд хадгалагдаж байгаатай холбоотойгоор гадаад валютын урсгал сайжирч, төгрөгийн ханш болон гадаад секторын тогтвортой байдлыг дэмжиж байна. Үүний үр дүнд 2026 оны 9-р сарын байдлаар гадаад валютын улсын албан нөөц 8.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 51 хувиар өссөн байна. Цаашид уул уурхайн экспортын хэмжээ болон түүхий эдийн үнэ өндөр түвшинд хадгалагдах эсэх нь гадаад секторын тогтвортой байдал, төлбөрийн тэнцлийн төлөвийг тодорхойлох гол хүчин зүйл хэвээр байх төлөвтэй байна.

РРТ 3. ИНФЛЯЦ

- Эдийн засгийн гол эрсдэл бол инфляцын өсөлт болж байна. Инфляцын түвшин мах, шатахууны үнийн өсөлт зэрэг нийлүүлэлтийн гаралтай хүчин зүйлсийн нөлөөгөөр гуравдугаар улиралд эрчимжиж, 9-р сарын байдлаар жилийн инфляц 12.9 хувьд хүрээд байна. Үүнтэй холбоотойгоор Монголбанк 8-р сард бодлогын хүүг 12.5 хувь болгон нэмэгдүүлж, 9-р сарын хурлаар уг түвшинг хадгалсан. Цаашид улсын төсвийн тодотголын хүрээнд урсгал зардал нэмэгдэхээр байгаа нь дотоод эрэлтийг тэлж, эрэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна. Иймд Төв банк инфляцын хүлээлтийг тогтворжуулах зорилгоор мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлэн баримтлах төлөвтэй байна.

РРТ 4. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

- Мөнгөний бодлого хатуу төлөвт байгаатай холбоотойгоор банкны секторын зээлийн өсөлт саарч нийт зээлийн өсөлт 14.3 хувиар өссөн байна. Өмнөх жилүүдэд өсөлтийн хувь 20-30 хувиар тэлж байсан бол энэ жилийн хувьд хэрэглээний зээл саарч, харин бизнесийн зээл тогтвортой байгаа дүр зурагтай байна.

Онцлох үйл явдлууд

РРТ 1. FOREIGN FUNDING

- WaterEquity байгууллагын удирддаг Global Access Fund IV сангийн хүрээнд урт хугацаат санхүүжилтийг шинээр татан төвлөрүүллээ. Уг санхүүжилтийг цэвэр ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтийг дэмжих зорилгоор ашиглана.
- Олон улсын санхүүгийн корпорац (IFC)-ийн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд хоёр дахь транч эх үүсвэрийг татан төвлөрүүллээ. Уг санхүүжилтийг ногоон болон цэнхэр төслүүд, эмэгтэй бизнес эрхлэгчдийн жижиг, дунд бизнес, түүнчлэн жижиг, дунд бизнесийн санхүүжилтийг дэмжих зорилгоор ашиглана.
- Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (EBRD)-ны санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд хоёр дахь транч эх үүсвэрийг татан төвлөрүүллээ. Уг санхүүжилтийг эмэгтэй болон залуу бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, тэдний санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ашиглана.
- Ингээд Голомт банк 26 оны 3-р улиралд нийт 52 сая ам долларын эх үүсвэрийг олон улсын зах зээлээс амжилттайгаар татан төвлөрүүллээ.

PPT 2. London

Лондон хотноо Монголын Хөрөнгө оруулалтын форумыг CMM –тэй хамтран амжилттай зохион байгууллаа

Голомт банк олон улсын хөрөнгийн зах зээлийн форумыг хамтран зохион байгуулж, дэлхийн хөрөнгө оруулагчид болон салбарын төлөөлөгчдөд өсөлтийн стратеги, бизнесийн загвар, хөрөнгө оруулалтын боломж, дижитал шилжилтийн чиглэлээ танилцууллаа.

Арга хэмжээнд 150 гаруй төлөөлөгч, тэр дундаа олон улсын 127 гаруй хөрөнгө оруулагч болон хувьцааны хөрөнгө оруулалтын салбарын мэргэжилтнүүд оролцов.

Форумын хүрээнд Голомт банк Лондонгийн хамгийн том хөрөнгийн зах зээлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын нэг болох STJ Advisors компанитай хамтран Fireside Chat ярилцлага зохион байгуулж, банкны өсөлтийн түүх, өрсөлдөөний давуу тал, цаашдын төлөв болон хөрөнгө оруулалтын боломжийг танилцуулсан юм.

Мөн Голомт банк Монгол Улсын хиймэл оюуны өнөөгийн үе сэдэвт панел хэлэлцүүлгийг зохион байгуулж, Монголын тэргүүлэгч хиймэл оюуны компанитай хамтран хэрэгжүүлж буй Виртуал банкны төсөл, хиймэл оюунд суурилсан үйлчилгээний хөгжлийн чиглэл, дижитал шилжилтийн стратегиа танилцууллаа.

PPT 3. CEBEC

CIPS-ээс жил бүр зохион байгуулдаг CEBEC арга хэмжээ 2026 оны 9 дүгээр сарын 8-11-ний өдрүүдэд БНХАУ-ын Шиамен хотод, 26 дахь удаагийн CIFIT хөрөнгө оруулалтын экспотой хамтатган амжилттай зохион байгуулагдав. Энэхүү арга хэмжээнд CIPS-ийн шууд оролцогч 80 гаруй банк, 20 гаруй улсын төлөөлөгч оролцож, CIFIT экспод нийт 129 улсын 100 мянга гаруй зочин, төрийн болон хувийн хэвшлийн 1,200 гаруй байгууллагын төлөөлөл хүрэлцэн ирсэн байна. Голомт банк үзэсгэлэнд оролцон бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулж, Хятад, Монголын худалдаа, төлбөр тооцооны салбар дахь хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн ололт амжилтаа хуваалцлаа.

Арга хэмжээний хүрээнд Голомт банк Agricultural Bank of China-тай CIPS системийг амжилттай нэвтрүүлсний нэг жилийн ойг тэмдэглэж, мөн Bank of China-ийн Шиамен салбар болон C&D Inc.-тэй гурван талт хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан, Хятад, Монголын хоорондын төлбөр тооцоо, худалдааны санхүүжилтийн хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тохиролцов.

PPT 4. Blue Bond Guidelines

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх тухай конвенцын Талуудын 17 дугаар бага хурал COP17 Mongolia-ын хүрээнд Голомт банк нь Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбооны манлай банкны хувьд өндөр оролцоотой ажилласан. за энэ хүрээнд хийгдсэн онцлох ажлуудыг дурьдья

Монгол Улс усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор “Цэнхэр бонд гаргах удирдамж”-ийг боловсруулан танилцууллаа. Энэхүү удирдамж нь усны нөөцийн менежмент, усан хангамж, усны бохирдлыг бууруулах, цэнгэг усны экосистемийг хамгаалах чиглэлд санхүүжилт татах үндэс суурийг бүрдүүлж буйгаараа онцлог юм.

Ус нь эдийн засгийн хөгжил, нийгмийн сайн сайхан, байгаль орчны тогтвортой байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий үнэт нөөц юм. Манай орны усны хэрэглээний дийлэнх хэсгийг газрын доорх ус хангадаг ч уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, усны нөөцийн хомсдол, бохирдол болон усны экосистемийн доройтол зэрэг сорилтууд улам нэмэгдсээр байгаа нь энэ салбарт чиглэсэн хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх хэрэгцээ шаардлага бий болж байгааг илтгэж байна. Мөн дэлхий дахинаа далайд гарцгүй 44 улс байдаг ч тэдгээрийн нөхцөл, хэрэгцээ, онцлогт тохирсон Цэнхэр бонд гаргах удирдамж бүрэн хөгжөөгүй хэвээр байгаа юм. Иймд Монгол Улс өөрийн усны нөөцийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Цэнхэр бонд гаргах удирдамжийг боловсруулсан нь олон улсын хэмжээнд жишиг болохуйц цоо шинэ санаачилга боллоо.
Цэнхэр бонд гаргах удирдамжийг Санхүүгийн зохицуулах хороо, Голомт банк, Тогтвортой санхүүгийн холбоо хамтран ОУСК-ийн техникийн тусламжтайгаар боловсруулан баталсан бөгөөд усны нөөцөөс шууд хамааралтай эдийн засгийн салбаруудад тулгамдаж буй усны хомсдолын эрсдэлийг бууруулах, тогтвортой усны нөөцийн менежментийг бэхжүүлэхээр зорьж байна.

PPT Blue finance framework

Голомт банк байгаль орчин, усны нөөцийг хамгаалах, тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй санхүүжилтийн үйл ажиллагаагаа олон улсын нийтлэг зарчим, стандартад нийцүүлэх зорилгоор “Цэнхэр санхүүжилтийн хүрээ” (Blue Financing Framework) баримт бичгийг боловсруулан гаргалаа.

Тус баримт бичиг нь усны нөөцийг хамгаалах, усны хүртээмжийг нэмэгдүүлэх, ус болон бохир усны тогтвортой менежментийг дэмжих, цэнгэг усны экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, мөн тогтвортой аялал жуулчлал болон усны нөөцтэй холбоотой байгальд ээлтэй үйлдвэрлэл, дахин боловсруулалтыг дэмжих санхүүжилтийн үндсэн чиглэлүүдийг тодорхойлж байна.

“Цэнхэр санхүүжилтийн хүрээ”-г олон улсын хөрөнгийн зах зээл, тогтвортой санхүүжилтийн зарчимтай нийцүүлэн боловсруулсан бөгөөд S&P Global Ratings байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ, баталгаажуулалт хийлгэснээр баримт бичгийн найдвартай байдал, ил тод байдлыг олон улсын түвшинд баталгаажууллаа.

Ингэснээр Голомт банк нь усны нөөц болон усны экосистемийг хамгаалахад чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдэд тогтвортой санхүүжилтийг нэмэгдүүлэх, байгаль орчны эерэг үр нөлөө бүхий хөрөнгө оруулалтыг дэмжих боломжоо өргөжүүлж байна.
Энэхүү санаачилга нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтууд, байгаль орчны хамгаалал болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулахад санхүүгийн салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

PPT Бумбат

Монгол Улсын “Усны элч” Голомт банк нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжин санхүүжүүлсэн “Бумбатын хөв цөөрмийн төсөл” бүрэн хэрэгжиж, өнөөдөр буюу 8-р сарын 18-ны өдөр нээлтийн ёслолоо хийлээ.
Тус төсөл нь Улаанбаатар хотын гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх, усны эх үүсвэрийг хамгаалах, үерийн эрсдэлийг бууруулах, иргэдийн амарч зугаалах таатай орчныг бүрдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.
Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр усны нөөц, экосистемийн тэнцвэрт байдал алдагдах эрсдэл нэмэгдэж байна. Иймд Бумбат булгийн эхийг хамгаалах, усны нөөцийг нэмэгдүүлэх, зохистой ашиглах, байгаль орчны тогтвортой байдлыг дэмжих зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлсэн билээ.

Төслийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Бумбатын рашаан болон Баруун салааны голын усыг хуримтлуулан 16.9 мянган шоо метр багтаамжтай усан сан бүхий хөв цөөрмийг байгууллаа. Мөн иргэдийн ая тухтай амрах орчныг бүрдүүлэх зорилгоор 840 метр урт явган хүний зам, гэрэлтүүлэг, хяналтын камер, ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

“Бумбатын хөв цөөрөм” төсөл нь Голомт банкнаас хэрэгжүүлж буй усны нөөц хамгаалах, байгаль орчны тогтвортой байдлыг дэмжих, хотын орчны чанарыг сайжруулахад чиглэсэн нийгмийн хариуцлагын томоохон санаачилгуудын нэг бөгөөд Голомт банк энэхүү бүтээн байгуулалтыг дэмжин нийт 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгон, дэмжиж ажиллалаа.

PPT Оюутан

Голомт банкны нэрэмжит “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийн 2026 оны шилдэг 100 оюутан тодорлоо

Анх 2003 оноос эхлэн бизнесийн байгууллагуудаас анхлан санаачлан хэрэгжүүлж эхэлсэн “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр” энэ жил 22 дахь удаагаа зохион байгуулагдлаа. Энэ жилийн хөтөлбөрийн хувьд хамгийн их буюу 2,000 гаруй оюутан залуус материалаа ирүүлж 3 шатны шалгаруулалтаар 2026 оны шилдэг 100 оюутан тодорч тэтгэлгээ гардан авлаа.

Бусад тэтгэлэгт хөтөлбөрөөс ялгаатай, хамгийн гол онцлог нь мэргэжил харгалзахгүй олгодог бөгөөд Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн 3, 4 дүгээр дамжааны, оюутнууд хамрагддаг.

Голомт банк “Ажиллахад таатай газар”-аар тав дахь жилдээ дараалан өргөмжлөгдлөө

Голомт банк олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Ажиллахад таатай газар”-аар тав дахь жилдээ өргөмжлөгдөж, “5 year icon” батламж авч буй Монгол Улсын анхны байгууллага боллоо. Анх 2022 онд Монгол Улсын банк санхүүгийн салбараас түүчээлэн “Ажиллахад таатай газар”-аар батламжлагдаж байсан бол өдгөө жил бүр амжилтаа тогтмол өсгөн бэхжүүлж, олон улсын түвшинд дахин үнэлэгдлээ. Энэ жилийн үнэлгээ нь 92% тай гарсан нь Ази тивийн дунджаас 2%, Монгол улсын дунджаас 10% илүү үзүүлэлт болсон нь бидний бахдам амжилт юм.

“Ажиллахад таатай газар” батламжийг олон улсын “Great Place to Work Institute”-ээс сүүлийн 30 гаруй жилийн турш 90 гаруй улсын 11 сая ажилтнаас жил бүр судалгаа авч, тухайн байгууллага нь “Ажиллахад таатай газар” эсэхийг хараат бусаар үнэлдэг. Голомт банкны тухайд ажилтнуудынхаа итгэлцэл, хүндлэл, нөхөрлөл, бахархал, шударга байдлыг бэхжүүлж, хамтран ажиллахад таатай орчныг бүрдүүлэн ажилласан нь олон улсын түвшинд тав дахь жилдээ баталгаажсан тул энэхүү хүндтэй батламжийг “Great Place to Work”-ийн бүс нутгийн төлөөлөгчид гардууллаа. Мөн “Great workplaces summit” арга хэмжээний үеэр Голомт банк “Ажиллахад таатай газар” болсон туршлагаасаа хуваалцсан юм.

PPT . Онцлох бүтээгдэхүүн Nature virtual card

Голомт банк байгаль орчинд нөлөөлөх эрсдэлийг санхүүгийн шийдвэр гаргалтад тусгах чиглэлээр хамтран ажиллаж, биологийн олон янз байдлын эрсдэлийг нарийвчлан тооцох аргачлал нэвтрүүлэх, чадавх бэхжүүлэхээр зорьж байна. Мөн байгаль хамгаалалд банк, санхүүгийн салбарын оролцоог нэмэгдүүлэх, байгальд ээлтэй хэрэглээг дэмжих зорилгоор “Nature” виртуал карт гаргаж байна. Энэхүү картаар дамжуулан картын хураамжийн орлогын 80 хувийг Монголын байгалийн өв санд хандивлаж, Монгол Улсын дархан цаазат газар, тусгай хамгаалалттай болон байгалийн дурсгалт газруудыг хамгаалах үйлсэд бодитой хувь нэмэр оруулах юм.

PPT . Онцлох бүтээгдэхүүн Samsung Wallet

Samsung Wallet

Голомт банк харилцагчдынхаа өдөр тутмын төлбөр тооцооны хэрэглээнд илүү хялбар, дэвшилтэт шийдлийг нэвтрүүлэхийг зорин олон улсад хамгийн өргөн хэрэглэгддэг дижитал хэтэвчүүдийг амжилттай нэвтрүүлж, нутагшуулаад буй

Samsung Wallet нь төлбөрийн карт, үнэмлэх, тасалбар, лоялти карт, нууц үг, дижитал түлхүүр зэрэг олон төрлийн мэдээллийг нэг дор хадгалах нэгдсэн платформ юм. Өөрөөр хэлбэл, Samsung Pay-ийн бүх боломж Samsung Wallet-д багтсан.

Харилцагчийн гол өгөөж:
Илүү хялбар хэрэглээг санал болгож байгаа за тухайлбал – Карт, тасалбар, эрхийн бичиг зэрэг бүх хэрэгцээг нэг апп-аас ашиглана.
Түргэн төлбөрийн хэрэгсэл болно – Утас эсвэл цаг ашиглан шууд төлбөр хийх боломжтой.
Өндөр аюулгүй байдалд суурилдаг - Биометр баталгаажуулалт болон хамгаалалтын технологи ашиглана.
За мөн Автомашины түлхүүр, тасалбар, нууц үг зэрэг олон төрлийн үйлчилгээг нэг цэгээс удирдана.

PPT 1. Санхүүгийн ерөнхий үзүүлэлт

- Голомт банкны 2026 оны гуравдугаар улирлын санхүүгийн үр дүнг танилцуулъя.
- Тайлант хугацаанд банкны голлох санхүүгийн үзүүлэлтүүд тогтвортой өсөлтөө хадгалж, зах зээл дэх тэргүүлэгч байр сууриа бататгалаа.
- Нийт хөрөнгийн хэмжээ 554 тэрбум төгрөгөөр буюу 2.9 хувиар өсөж, 19.6 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд зах зээлийн нийт хөрөнгийн 20 хувийг бүрдүүлж байна.
- Мөн нийт зээлийн багц 431 тэрбум төгрөгөөр буюу 5.2 хувиар нэмэгдэн 8.7 их наяд төгрөгт хүрч, зах зээлд эзлэх хувь 18 хувь болсон үзүүлэлттэй байна.

- Харилцагчдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн зах зээлд эзлэх хувь 18 хувьд хүрлээ.

PPT 2. Зээлийн багцын өсөлт ба чанар

- Зээлийн багцын бүтэц, чанарын үзүүлэлтийг дэлгэрүүлэн авч үзье.
- Багцын бүтцийг харвал бүтээгдэхүүнүүдийн хооронд харьцангуй жигд төрөлжилт хадгалагдаж байна.
- Банк жижиг, дунд бизнесийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны үр дүнд ЖДБ-ийн зээл нийт бизнесийн зээлийн багцын 53 хувийг эзэлж байна.
- Иргэдийн зээлийн хувьд хэрэглээний зээл 6.1 хувиар, орон сууцны зээл 20 орчим хувиар өслөө.
- Зээлийн чанарын үзүүлэлтүүд тогтвортой түвшинд хадгалагдсан бөгөөд чанаргүй зээлийн харьцаа 2.7 хувь, чанаргүй зээлд байгуулсан сангийн хүрэлцээ 97.7 хувьтай гарлаа.

PPT 3. Эх үүсвэр ба төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

- Эх үүсвэрийн бүтэц болон хөрвөх чадварын үзүүлэлтүүдийг харвал.
- Харилцагчдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэр оны эхнээс 6.3 хувиар өссөн бөгөөд уг өсөлтийн голлох хэсгийг харилцах өсөлт бүрдүүлсэн байна.

- Зээл, эх үүсвэрийн харьцаа 74 хувь, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 42.9 хувьтай байна.

РРТ 4. Ашигт ажиллагаа ба өөрийн хөрөнгө

- Ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн үзүүлэлтийг харвал.
- Тайлант хугацаанд татварын дараах цэвэр ашиг 227.8 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт өөрийн хөрөнгө 266 тэрбум төгрөгөөр буюу 17 хувиар өсөж, 1.8 их наяд төгрөгт хүрээд байна.
- Түүнчлэн банкны бүх харьцаа үзүүлэлт Монголбанк болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас тогтоосон шалгуур шаардлагыг бүрэн хангаж байна.